



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 07 өдөр

Дугаар A/69

Хархорин сум

Газар эзэмших эрх шинээр олгох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 11 дүгээр сарын 24-ны өдрийн "Сумын 2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тухай" 17/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэр Соёмбо хороолол 1а тоотод байрлалтай 0,24 га (2400м²) газрыг төрийн захиргааны байгууллагын зориулалтаар (8321892)-д Шинэ Хархорум хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргаанд 60 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

2.Газрын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн холбогдох заалтыг мөрдөж ажиллахыг дарга (Н.Нацагдорж)-д үүрэг болгосугай.

3.Газар эзэмшигч Шинэ Хархорум хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргаанд гэрээ байгуулан, гэрчилгээ олгох, улсын бүртгэлд бүртгэхийг сумын Газрын даамал (Ч.Баттулга), (Э.Дэнсмаа) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ОДГЭРЭЛ

491190137